

БАТЛАВ. МОНОСХҮНСХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А.ОТГОНДАРЬ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН /БОНЗ/ БОДЛОГО

Агуулга

Өмнөтгөл.....	2
Бидний тухай:.....	2
Бодлогын зорилго:.....	2
БОНЗ амлалт:.....	2
1. Байгаль орчны бодлого	2
2. Нийгмийн бодлого.....	2
3. Засаглалын бодлого.....	3

Өмнөтгөл

Бидний тухай:

Монос Хүнс ХК нь ард иргэдийнхээ эрүүл мэндийг дэмжих зорилготойгоор Монгол орны хөрсөнд ургасан эмийн ургамлын түүхий эдийг ашиглан амин дэм, эрдэс бодисоор баялаг хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг билээ.

Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх судалгаанд дурдагдсан зонхилон тохиолдох өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нэн тустай эрүүл мэндийн хуурай болон шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зөв дадлыг амьдралдаа хэвшүүлэхэд нь туслахыг онцгойлон анхаарахыг эрмэлздэг.

Бодлогын зорилго:

Бодлогын гол зорилго нь БОНЗ /Байгаль Орчин, Нийгэм, Засаглал/-ын нэгдсэн чиглэлтэй байж компанийн нийт үйл ажиллагаанд баримтлал болгон БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулахад оршино.

БОНЗ амалт:

- Монос Хүнс компани нь хариуцлагатай БОНЗ-н тогтолцоог бүрдүүлж, шударга ёс зүйтэй байхыг сурталчлан таниулна.
- Бид байгалийн нээцийг зөв зохистой ашиглан үйлдвэрлэл эрхлэхдээ хаягдалгүй үйлдвэрлэлийг бий болгохыг зорьж, сав ертөнцөд зэрэгцэн оршиж буй биологийн олон янз байдлыг хүндэтгэн ажиллаж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгаж, ирээдүй үр хойчдоо экологийн тэнцвэрт байдлыг хангаж үлдээхэд чиглэж ажиллана.
- Бид зохистой худалдан авалтыг дэмжиж, тогтвортой ханган нийлүүлэлтийг дэмжин ажиллана.
- Бид БОНЗ-ын үлгэр жишээ соёлыг хэвшүүлэхэд ажилтан бүрийн оролцоог ханган, зохистой хөдөлмөрийн харилцааг эрхэмлэн, эрүүл аюулгүй, хүнд ээлтэй ажлын байрыг бий болгоход эрмэлзэнэ.

1. Байгаль орчны бодлого

- Байгаль орчны тэнцвэр, тогтвортой байдлыг хадгалах, хамгаалах, сайжруулахыг үйл ажиллагаандаа урьтал болгож харилцагч, хамтрагч, олон нийтэдuriалан сурталчлах замаар байгаль орчны манлайлагч байна.
- Байгаль орчны менежментийн олон улсын стандартыг нэвтрүүлэн үйл ажиллагаанд хэвшүүлж түүний шалгууруудыг ханган ажиллана.
- Үйл ажиллагаанаас үүдэлтэй үүр амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлс, хүлэмжийн хийн ялгарал болон агаар, ус, хөрсний бохирдлыг боломжит хамгийн бага байхад тэмүүлнэ.

2. Нийгмийн бодлого

- Бид оролцогч талуудтай харилцах бүхий л үйл ажиллагаандаа хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хүндэтгэнэ.

- 2.2. Бид ажлын байрны зохистой хөдөлмөр эрхлэлт, ажилтны эрх тэгш оролцоо, цалин урамшуулал, ажиллах нөхцөлийн зохистой харилцааг дэмжин, дарамт, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлэг, албадан хөдөлмөр эрхлэлт, олон талт ялгаатай байдлын ялгаварлан гадуурхалтгүй ажиллана.
- 2.3. Бид хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлгүй ажлын байр, нөхцөл боломжоор хангаж, үйлдвэрийн осолгүй байх дээр хичээж ажиллана.
- 2.4. Бэлтгэн нийлүүлэгчдийн өрсөлдөөнийг тэгш боломжоор хангах, бэлтгэн нийлүүлэгчтэй хоёр талын харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгон үр ашигтай хамтран ажиллахыг эрхэмлэх, компанийн өртөг зардлыг бууруулж, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллана.
- 2.5. Олон улсын стандарт, хуулийн шаардлагын дагуу, судалгаа шинжилгээгээр баталгаажсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээндээ хүнсний аюулгүй байдал болон чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулж ажиллана.

3. Засаглалын бодлого

- 3.1. Бид бизнесийн үнэ цэнийг урт хугацаанд тогтвортой, өсөлттэй байлгахын тулд байгууллагын бүх түвшинд үдиридлагын зохистой манлайллыг эрхэмлэж, үлгэр жишээ ч хариуцлагатай, шүдрага байдлаар дамжуулан компанийн ёс зүйтэй засаглалыг баримтална.
- 3.2. Мэдээллийн ил тод байдал, хуулийн нийцлийг хангаж, хээль хахууль авлига, хувийн ашиг сонирхлоос ангид ажиллана.

2023.10.02